

2009 ЖИЛИЙН ТАЙЛАН



ANNUAL REPORT 2009

АГУУЛГА

- Тэргүүний мэндчилгээ
- Захирлын мэндчилгээ
- 2009 оны үйл ажиллагааны тойм
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх
- 2009 оны тэтгэлэг авагчдын амжилтаас
- 2009 онд олгосон тэтгэлэгүүд
- Санхүүгийн тайлан
- Манай хандивлагчид
- Манай хамт олон
- МОНЭС-ийн хамтын ажиллагаа
- ОУЭСС уулзалт Монголд
- МОНЭС-ийн 10 жилийн ой
- Хэвлэл нийтлэл

CONTENT

- Greetings from the Head..... 4
- Greetings from the Director..... 5
- 2009 in Brief..... 6
- Development of the women's movement..... 8
- Grantees achievements..... 11
- Grants successes..... 17
- Financial report..... 19
- Our supporters..... 20
- Our team..... 21
- MONES Networking..... 23
- INWF Conference..... 24
- MONES 10 year anniversary..... 25
- Publications and media..... 26



МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН
/МОНЭС/

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН
/МОНЭС/

Монголын Эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөө, хөгжил дэвшилийн төлөө ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн ТББ, үүсгэл санаачлагын бүлгүүдийг дэмжин ажилладаг филантропи байгууллага юм.

Эмэгтэйчүүдийн амьдралыг илүү аз жаргалтай болгохын тулд тэдний оролцоотойгоор эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлж нийгмийг өөрчлөн сайжруулна.



OUR MISSION

MONGOLIAN WOMEN'S FUND (MONES)

is the philanthropic organisation that supports women's organisations and groups that work for advancement and protection of women's human rights, freedom and development of Mongolian women.

We strive to achieve social change and make the lives of women happier and healthier through increasing women's participation and strengthening women's movement.



ТЭРГҮҮНИЙ МЭНДЧИЛГЭЭ



Ш. ЦЭВЭЛМАА
Тэргүүн
Монгол Улсын Аянхы
Тэргүүн Хатагтай

TSEVELMAA SH.
Head of MONES
Former 1st Lady of
Mongolia

Хүний эрхийн зөрчил, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт, насанд хүрээгүй охидын төрөлт зэрэг нийгмийн олон бэрхшээлтэй асуудлын төлөө ажилладаг ТББ-уудыг байнга дэмжиж ирсэн билээ.

Манай Сан Монголын шилдэг эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд хүргэхийн тулд идэвхтэй ажиллаж ирлээ. Үүнийхээ үр дүнд сэтгэл ханамжтай байна.

МОНЭС нь Олон улсын Эмэгтэйчүүдийн Санггуудын Сүлжээ, Америкийн Эмэгтэйчүүдийн Санггуудын Сүлжээ, Ази, Номхон Далайн бусийн орнуудын Эмэгтэйчүүдийн Санггуудын Сүлжээтэй нягт хамtran ажиллаж ирлээ.

Бусдын сайн сайхны төлөө, нийгмийн хөгжлийн төлөө, нинжин сэтгэлийн хандив өргөх дэлхий нийтийн сайн санааны үйлс болох филантропийн сэтгэлгээг эх орондоо үүсгэсэн анхны байгууллага болж чадсандаа бид баяртай байдаг юм.

Бидний үйл ажиллагааг цаг ямагт дэмжиж, бидэнтэй хамtran ажилладаг бүх төрийн бус байгууллага, тэдгээрийн хамт олонд талархлаа илэрхийлье. Дотоод гадаадын бүх хандивлагчиддаа гүн талархлаа илэрхийлж, цаашдын ажилд тань амжилт хүсье.

10 жилийн турш хуримтлуулсан сургамж туршлагаар баяжин, өсөн торnisон МОНЭС-ын ажлын албаныхандаа улам ихээр ахин дэвших амжилт, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөө.

GREETINGS FROM THE HEAD OF MONES

Dear sisters and friends,

It is been 10 years since the establishment of MONES. The most sensible intelligent leaders in society were our partners through all these years. MONES sends her 10 year anniversary congratulations to all our friends, supporters and partners.

Since its establishment, MONES has been raising funds to support women's groups and organisations that work for the advancement of women and the protection of women's human rights and to promote a just and better society by cultivating philanthropy.

MONES strives to create an environment for women to fully participate in social and economic life; to promote women's initiatives and their best techniques and experiences; and to create an opportunity for learning and sharing through teamwork; also, to build the capacity of the women leaders of organizations and groups.

MONES continued to support the work of organizations working on teenage pregnancy, combating the sexual harassment in the workplace, tackling domestic violence and other forms of violations of women's human rights.

MONES also worked with strong professional women to support them on their way to decision making levels, and the outcomes of this collaboration are very heartwarming and satisfying.

We cooperated closely with the International Network of Women's Funds, Women's Funding Network and Asian Network of Women's Funds.

We are proud to be the first organisation that cultivates the culture of giving for the good of society and the philanthropy in Mongolia.

Our special gratitude to all organisations and their staff that have worked with us and supported our work through our 10 years. Our deepest gratitude and best wishes to all our Mongolian and international donors!!

Our sincere thanks and best wishes of growth and advancement to our staff that grew and progressed together with MONES during the past 10 years.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Бид ямагт аз жаргалтай, баяр баясгалантай амьдрахыг хүсэн мөрөөддөг. Тэгвэл сайхан амьдрал гэж юу вэ? магадгүй зарим нь их хэмжээний “эд баялаг” гэж санах байх, гэвч заримд нь зөвхөн өдөрт идэх хоол төвөггүй олдож байгаагаа “сайхан” гэж болох юм. Харин бид хүн болж төрснийхөө хувьд жам ёсны эрх, эрх чөлөөгөө өдлэн, аз жаргалтай амьдралыг эрэлхийлэх боломжтой хүмүүнлэг, шударга нийгмийг эмэгтэйчүүдийн оролцоотой байгуулж болно гэж үздэгт билээ.

Бид үүнийг яаж хийх вэ? Аливаа өөрчлөлтөд хүрэхийн тулд нийгмийн, хамтын соёл руу шилжих нь хөгжилд хүрэх дөт зам байж болох юм.

МОНЭС өнгөрсөн бүхий л хугацаанд эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааг үнэлж ирсэн бөгөөд үүнийг ч дэмжиж ирсэн. Энэ нь бэрхшээлтэй, удаан ч өөрчлөлт шинчлэлт авчирч болохыг олж харсан. Эмэгтэйчүүдэд арвин баялаг туршлага байдаг. Жишээ нь, Завханы эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хамтран ажиллаж сайхан амжилт гаргасан туршлагаас бусад нь суралцаж байхад төсвийн зарцуулалтанд хяналт мониторинг хийхдээ гайхамшигтай амжилт гаргаж байгаа Өвөрхангайн эмэгтэйчүүдээс бусад нь сурч байна. Зүүн бусийн эмэгтэйчүүд ч ялгаагүй эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд бусээрээ хамтран бие биенээсээ суралцаж байна.

Тэгвэл нийслэлд байрлах Эмэгтэйчүүдийн байгууллагууд охид, эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлтэй асуудал болох эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд эвсэл, сүлжээ болон янз бүрийн кампанийт ажлуудыг өрнүүлж байна. Хууль эрх зүйн орчинг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна. Дээрх эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүд бие биенээсээ суралцах тэр боломжийг бүрдүүлэхийн төлөө МОНЭС ажиллаж эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Ялангуяа өөрчлөлтийг авчирч чадах манлайлагч эмэгтэйчүүдийг бий болгох, чадваржуулах, алсыг харсан зорилго чиглэлийг нь тодорхой болгох, тэдний хамтын санал санаачлагыг дэмжих, урам зориг, баяр баясгаланг өгснөөр “бид өөрсдөө нийгмээ өөрчилж болох юм байна” гэдгийг олж танин олсон амжилтаа алдахгүйн төлөө хичээн ажиллаж чаддаг болж байна.

МОНЭС 2009 онд ийм арга барилаар ажиллаж бусийн төвүүдийг хөгжүүлэх, мөн түүгээр дамжуулан эмэгтэйчүүдийг өөрчлөх замаар нийгмийт өөрчлөхийн төлөө ажиллалаа. Бид нэг эмэгтэйд гарсан жижиг өөрчлөлт ч бүх эмэгтэйчүүдэд хүрээсэй гэж хүсдэг билээ.

Бидэнд санхүү нөөц бага олдсон ч хүрсэн амжилтая алдахгүйн төлөө хичээн ажиллах нь чухал. Бидэнд бүлэг нөхөрлөлтэй ажиллах, тэдний хамтын ажиллагааг сайжруулах, нөлөөлөл хийхдээ бусдыг сургах чадварлаг мэргэшсэн баг бэлдэх шаардлага урган гарч байна.

Үүний тулд филантропийг улам бүр баяжуулах, дотоод чадавхия сайжруулах, хамтрагчиддаа өөрсдийгээ таниулах олон талт ажлуудыг хийх хэрэгтэй байна. 2010 онд Олон Улсын Эмэгтэйчүүдийн Санггуудын Ээлжит уулзалт Улаанбаатар хотноо болно. Бидэнтэй сэтгэл зүрхээрээ байнга хамт байдаг эгч дүүстэйгээ эх орондоо уулзаж тэдний арвин баялаг туршлагаас суралцах сайхан боломж олдож байгаа нь МОНЭС-ийн хамт олон болоод манай тэтгэлэгийг авч байгаа бүлгүүдэд ч урам зориг өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

GREETINGS FROM THE DIRECTOR OF MONES

We all want to lead happy and joyful lives. But what is living well? Some of us might think about the material riches, although for some others it is relief from worries about tomorrow's food.

We believe that humane and just society can be built with women's participation.

How can we achieve it? one of the ways might be communal culture rather than our nomadic self-centeredness

MONES has been supporting, and still is, women's networking and it proved to be an effective tool to achieve change, although it takes a long time and great effort.

Women are rich with experience, i.e. women of Zavkhan province have presented incredible capability in monitoring of the state budget; also, they serve to other rural women as an example of extraordinary teamwork and networking abilities shown in the project on women's political participation and at decision making levels, the same goes for women of Uvurkhangai province. Women from eastern regions of Mongolia came together to advance and develop the women in their areas.

Women groups and organisations in the capital are organizing various campaigns and advocacy activities on fighting all forms of violence against women. They are advocating the policymakers on laws and regulations.

MONES is working hard on strengthening and broadening the women's movement through creating opportunities for women's groups for peer-to-peer learning and networking. We have learned to retain our successes and move forward bringing up women-leaders that would have the abilities to change society; determining and directing their vision; supporting their collaboration and giving moral support. Although the funds were limited we have done all the best to keep on going and from this we have learned we need to concentrate on capacity building of NGOs in advocacy activities, on collaboration and networking, and cultivating philanthropic culture in Mongolia. We also, need to concentrate on internal development and marketing of our organisation.

In May, 2010 the International Network of Women's Fund will hold its conference in Ulaanbaatar. We believe this is a great opportunity to enable MONES and her grantees to learn and share knowledge with our international sisters.



Н.ЧИНЧУЛУУН
Захирал
CHINCHULUUN
Director





2009 ОНЫ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

САН БҮРДҮҮЛЭЛТ

2009 оны санхүүгийн жил (Нэг сараас 12 сарыг дуустал) бид Mama Cash, Дэлхийн эмэгтэйчүүдийн сан, Германы Эмэгтэйчүүдийн сан, Филиа, Канад сан, Нидерландын Элчин сайдын яам, Чаннел сан, Германы Натур менц култур сан, Яаралтай тусlamжийн сан, Дэлхийн банк, ХААН банкны дэмжлэгтэйгээр байгууллагын тогтвортой ажиллагаа болон хөтөлбөрүүдийг санхүүжүүллээ.

Мөн манай байгууллагын чадвхийг бэхжүүлэхэд Олон Улсын Эмэгтэйчүүдийн Сангудын Сүлжээ, Эмэгтэйчүүдийн Сангудын Сүлжээ, Иргэний нийгмийг хөгжүүлэх болон Фордын сан чин сэтгэлээсээ хандсан юм.

Эдгээрийн үр дүнд 2009 онд нийтдээ 230,3 сая төгрөгийн орлого олж 78,5 %-ийг тэтгэлэг олгох хөтөлбөрийн уйл ажиллагаа, үлдэх хувийг байгууллагын тогтвортой уйл ажиллагааг хангахад зарцууллаа.

Филантропийн соёл, хөгжлөөсөө хамааран санхүүжилт олох үүд хаалга тийм ч хялбар байгаагүй хэдий ч бид амжилтаа алдахгүйн төлөө хичээн ажилласан юм.



ФИЛАНТРОПИЙГ ХӨГЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

МОНЭС Филантропийн соёлыг Монголд түгээхийг зорьж байна. Бид жил бүрийн 11 сард Олон улсын филантропи өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг билээ.

Энэ өдрүүдээр:

- Бусдын сайн сайхны төлөө халуун сэтгэлийн гарсаа сунгадаг Хандивлагчидад алдаршуулдаг.
- Хандивлагчдын тусlamж дэмжлэгийг хүлээн авдаг эмэгтэйчүүддээ урам өгдөг
- Олон нийтэд Эмэгтэйчүүдийн төлөө хандив өргөхийг уриалж хандив цуглуулдаг.
- Шинэ шинэ хандивлагчдыг эгнээндээ нэгтгэхийг зорьж “найзын сүлжээ”-г зохион байгуулдаг.

2009 онд 7 дахь жилдээ зохион байгуулсан Филантропчдын өдөрлөгөөр 705,3 мянган төгрөгийн хөрөнгө босголоо.

Энэ мөнгийг давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадваржуулахад зориулна.



88 ХОНОГИЙН КАМПАНИЙ АЖИЛ

Хүний эрхийн өдрөөс Эмэгтэйчүүдийн эрхийн өдөр хүртэл 88 хоног

“Охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалья” уриан дор хандив цуглуулах ажиллагаа өрнүүлж Эмэгтэйчүүдийн Сангудын Сүлжээнээс гаргасан “Саян төлөө эмэгтэйчүүд” номыг орчуулан гаргаж үзэл санааг бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдийн дунд сурталчилж нийт 584,4 мянган төгрөгийн хандив цуглуулав.



ХАНДИВЫН ХАЙРЦАГ БА ДУГТУЙ

ХААН банкны Улаанбаатар хот дахь тооцооны салбар болон ХААН Банк Сан бидний уйл ажиллагааг байнга дэмждэгийг та бүхэн нэгэнт мэдэх билээ. ХААН банкны 23 тооцооны салбарт байрладаг МОНЭС-ийн хандивын хайрцааар 2009 онд 906,9 мянган төгрөг, хандивын дутгтуягаар 855 мянган төгрөгийн хандив цуглуулсан юм. Мөн ХААН Банк Сан бидний уйл ажиллагааг дэмжиж 2 сая төгрөгийн тэтгэлэг олгосныг өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй ээжүүдийн орлогыг нэмэгдүүлэхэд зориуллаа.

2009 IN BRIEF

FUNDRAISING

In 2009 we have received organisational development support and support for projects from Mama Cash, Global Fund for Women, Familia Foundation, Natur Mensch Kultur, Canada Fund, the Netherlands Embassy, Channel Foundation, Urgent Action Fund, the World Bank and the Khan Bank.

Also Ford Foundation, International Network of Women's Funds and Women's Funding Network have helped MONES with capacity building and organisational development.

As a result we have raised MNT 230,3 million (little over USD 150 thousand) and has used 78.5 percent for the grantmaking programme. The remaining balance was used to ensure sustainable operations of the Fund.

With the lack of philanthropic culture in Mongolia it is not easy to raise funds, but we have strived not to lose the previous successes and outcomes.



PHILANTHROPY CULTURE

MONES is one of the first organisations to start the cultivation of philanthropic culture in Mongolia. Every November we celebrate International Philanthropy Day.

This day is for:

- Promoting philanthropy through rewarding our donors.
- Encouraging our grantees and other grassroots groups
- Raising funds under the call to give for women
- Encouraging more individuals to donate we create “friends networks”.

We have raised MNT 705.3 thousand on the last Philanthropy Day celebrations.

We use this money to support, train and build capacity of women with multiple disadvantages.



88DAYS FUNDRAISING CAMPAIGN

From Human Rights Day till Women's Rights Day—88 days

This campaign is dedicated to raising funds to “Protect Girls and Women from Sexual Violence”. We have published a translated version of the book from the Women's Funding Network “Women Moving Millions” to present it to Mongolian businesswomen.

MNT 584.4 (approx USD 400) has been raised during this campaign. Money was used to pay for legal counselling of a girl-victim of sexual violence and bringing the violator to the court.



DONATION BOX AND ENVELOPES

Khan Bank and Khan Bank Fund are one of the best Mongolian donors of MONES, they have been supporting our work for many years allocating our donation boxes in their 23 branches. Through these we have raised MNT 906,9 thousand (USD 625), and MNT 855 thousand were raised through our donation envelopes. Khan Bank Fund has donated MNT 2 million in support of capacity building of women-family heads with many children.



МОНГОЛЫН
ДАУАЧИЛСАН
МОНГОЛЫН
ДАУАЧИЛСАН

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөнийг бэхжүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн бүлгүүд, тэдний манлайлажчдыг чадваржуулан нийгмийг өөрчлөхийн төлөө МОНЭС санхүүгийн дэмжлэг цэцүлдэг.
Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бүх орон даяар өрнүүлэхийг бид хүсч байна.

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НҮДЭР” ЧУУЛГАН



Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтсан ЭТББ-дын Чуулганыг МОНЭС анх 2006 онд санаачилж байсан бол түүнээс хойш одоог хүртэл санхүүжүүлэгч нь болон ажиллаж байна.

Жил бүр эмэгтэйчүүдийн байгууллагууд буухиалан авч зохион байгуулж, өргөжүүлэн утга агуулгын хувьд баяжуулан хөгжүүлж байгаа билээ. ЭТББ-ын

Үндэсний Сүлжээнээс 2009 онд зохион байгуулсан чуулган нь “Эмэгтэйчүүдийн нүдэр - Үндэсний аюулгүй байдал” гэсэн сэдвийн дор явагдлаа. Чуулганд 300 гаруй төлөөлөгчид оролцож Үндэсний аюулгүй байдалтай холбоотой 9 илтгэлийг хэлэлцсэн ба илтгэлүүдийг товхимол болгон холбогдох газруудад тарааж нөлөөллийн ажлуудыг хийсэн нь үр дүнгээ ёгсөн юм.

БҮСИЙН СУЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

МОНЭС эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг хөгжүүлэхийн тулд бусчилсэн хөгжлийн стратегийг чухалчилж байна.

Орон нутгийн эмэгтэйчүүд амжилт ололтоор дүүрэн байгаа төвийн байгууллагуудаас суралцах, мөн бие биенээсээ суралцах, суралцсанаа аймаг орон нутаг, сум багтаа хэрэгжүүлэх, гарсан амжилтад олон нийтэд түгээж байна. Эвсэл, сүлжээ болж ажиллаж байгаа энэ туршлагыг улсын хэмжээнд бүх аймаг орон нутагт түгээн дэлгэрүүхийн тулд бие биенээсээ суралцах Сургалтын аялал хийдэг билээ.

2009 онд Завханы эмэгтэйчүүд Өвөрхангай аймгийн эмэгтэйчүүдээс төсвийн мониторинг хийх арга туршлага, Увс аймгийн эмэгтэйчүүд УВ хотын болон Завханы ЭТББ-ын Сүлжээний амжилт ололтоос суралцаж өөрийн аймагтаа нэвтрүүлж байна.

Мөн Зүүн бүсийн Эмэгтэйчүүдийн байгууллагуудын туршлага солилцох уулзалт Багануур дүүрэгт зохион байгуулагдаа. Энэ бүх сургалт, суралцах аялал болон үйлажиллагааны зардлуудыг МОНЭС санхүүжүүлсэн юм.

ЗАЛУУ ЛИДЕР ЭМЭГТЭЙЧҮҮД

Бидний зорилтын нэг бол Залуу лидер эмэгтэйчүүдийг бэлтгэх явдал байв.

Залуучууд өөрсөддөө тулгардаг асуудлыг олж таних, улмаар үе тэнгийнхэндээ нөлөөлөх олон талт ажлуудыг зохион замаар чадваржин, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг баяжуулах нь юунаас ч илүү чухал юм.

Эссэ бичлэгийн уралдаанаар гараагаа эхэлсэн охид манлайллын тухай зуны сургалтаар мэдлэгээ баяжуулж, лидер эмэгтэйчүүдтэй уулзан туршлагаас нь суралцаж, хүйсийн тухай хэлэлцүүлэг өрнүүлж, нийтлэл бичиж, өөрийгөө хөгжүүлж улмаар хүрээгээ өргөтгэх зорилт тавин “Залуу лидер эмэгтэйчүүдийн клуб”-ыг байгуулаад байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨН СУДАЛГАА

Энэхүү судалгаа нь:

- Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын сүлжээ, эвсэл, холбоо, бүлгүүдийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх.
- Эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааны үр дүнд нийгмийн амьдралд гарсан өөрчлөлтийг үнэлэх.
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор судалгаа хийлээ.

Судалгааны үр дүнд Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь хөгжлийн эхний шатандаа байна. Ялангуяа феминизмийг манай нийгэм илүү сөрөг утгатай үг гэсэн дүгнэлтэд хүрчээ.



DEVELOPMENT OF THE WOMEN'S MOVEMENT

*MONES financially supports organisations and groups that work for strengthening of women's movement, creation of women-leaders and their capacity building; and the final goal is to bring social change.
We want to build a nationwide movement.*

"THROUGH WOMEN'S EYES" FORUM

In 2006 we have initiated and funded the conference for women's groups and NGOs to celebrate International Women's Rights Day and have remained the funder since.

Every year women's NGOs and groups actively attend, enrich the content and suggest themes and topics to be discussed at the forum.

In 2009 "Through Women's Eyes" IV Forum's topic was "National Security is Human Security". The aim of this forum was to examine, challenge, and analyze the current dominant conceptions of national security and promote reformulation of this concept centering on human security, paying specific attention to gender-based vulnerabilities.

Over 300 NGOs and organisations have attended the forum and discussed papers and works presented at the forum. The publications produced at this forum have been used in advocacy campaigns.



DEVELOPING RURAL NETWORKS

Since 2007 MONES has adopted the "Strategy on Rural Development" in order to strengthen the women's movement in rural areas.

Women in rural areas are rich with experience and successful practices. They actively learn and share with urban organisations, as well as with their rural neighbours.

To support the networking and collaboration of the rural NGOs sharing and learning trips were organized. In 2009 Zavkhan province NGOs visited Uvurkhangai and learned to monitor the allocated budget of the province. Uvs province NGOs have visited Zavkhan and learned from their successes. They have introduced some of them in their own province.

Also, women organisations and groups from eastern provinces have organized their sharing and learning meeting in Baganuur district of Ulaanbaatar. These trips and their administration costs are financed by MONES.

YOUNG WOMEN LEADERS

One of our objectives was to have a Young Women Leaders Club. The aim of this club was to create young women activists and leaders of younger generations.

Young girls and women have learned to identify problems girls and women of their age face, and have organized number of advocacy activities influencing youth and strengthening women's movement.

The club had its start-up with the essay contest. Now girls-participants have undergone a number of trainings on gender and women's human rights. They have organized lectures and meetings with the known women politicians and women at decision making levels. They have produced a number of articles, organized debate meetings and are constantly developing themselves.



WOMEN'S MOVEMENT STUDY

This study was commissioned by the Mongolian Women's Fund (MONES) in order to:

- identify obstacles to and effective strategies for promoting feminist movement-building in Mongolia.
- evaluate women's NGOs', groups', coalitions' operations and activities in movement building
- evaluate the social change women's groups, NGOs and initiatives bring

The outcomes of the study showed that the women's movement is in its beginning development stage. And "feminism" is generally perceived as rather negative term.



2009 ОНЫ ТЭТГЭЛЭГ АВАГЧДЫН АМЖИЛТААС

ШИЙДВЭР ГАРГАХ ТУВШИНД АЖИЛЛАЖ БАЙГАА ЭМЭГТЭЙЧҮҮД

Завхан аймгийн ЭТББ-ын “Өрнөх хөгжил” Сүлжээний эмэгтэйчүүд “Эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоо” бодлогын баримт бичигт боловсруулан Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан нь эмэгтэйчүүдийн талаар баримтлах Хөгжлийн бодлоготой болсон том амжилт юм.

Мөн төсвийн мониторинг хийх замаар төсвийг ил тод нээлттэй болгох асуудлаар амжилттай ажиллаж, өөрийн аймгийн Нэгдсэн эмнэлэгийн эмийн төсвийн хүрэлцээ, эмийн төсвийн зарцуулалт, эмийн хангамж, хүртээмжийн байдалд үнэлгээ хийсний үр дунд Эрүүл мэндийн газар сар бүр өөрийн байгууллагын төсвийн гүйцэтгэлийг олон нийтэд ил тод тавьдаг боллоо.

Сүлжээний гишүүн эмэгтэйчүүд өөрийн сумын 120 гаруй эмэгтэйчүүдэд сургалт явуулж бүлэг зохион байгуулж, эмэгтэйчүүдийг чадваржууллаа.

Улмаар давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх бэхжүүлэх, орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж эмэгтэйчүүдийг өөрөө өөртөө ажлын байр бий болгоход хувь нэмэр оруулжээ.



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

МОНЭС жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон талт ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлсээр ирлээ. Үүний нэг нь Хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян бөгөөд ХЭҮТ энэ аяныг санаачлан 12 дахь жилдээ тэмдэглэж байна. Аяны хүрээнд хэвлэлийн бага хурал, аймгуудтай видео хэлэлцүүлэг, “болзооны хүчин” сэдвээр оюутан залуучуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлж хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр асуудал хөндсөн өргөн сурталчилгаа явуулав.

Мөн Увс аймагт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төрийн анхан шатны болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хамтарсан багийг аймгийн төв болон Бөхмөрөн суманд байгуулж үйл ажиллагаагаа эхлэв. Үйл ажиллагааныхаа хүрээнд хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг зохион байгуулж, Улаантом сумын 2 багт гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй эмэгтэйчүүдийн судалгаа гаргав. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангах талаар сургалт, сурталчилгааны ажлуудыг хийж цаашид хийх ажлын төлөвлөгөөг гаргаад байна.

Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” төв нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж, эрхийг нь хамгаалах олон талт ажлуудыг хийж байна.



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийнхөн Иргэний нийгмийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдад учирч буй бэрхшээл, түүнийг даван туулахад аливаа эрсдэлээс хамгаалах төрийн дэмжлэг, хамгаалалт нэн шаардлагатай болохыг тэр засаг, олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор “Хүний эрхийг хамгаалагчдад хамгаалалт хэрэгтэй юу?” сэдэвт нийтлэлийг сонин хэвлэлд тавьж олон нийтийн анхаарлыг хандууллаа.

Мөн оюутан сурагчдын дунд “Монгол дахь хүний эрхийн хамгаалал” сэдэвт хэлэлцүүлэг өрнүүлсний үр дунд хуулийн сургууллийн оюутнууд ТББ-ын үйл ажиллагаанд өөрсдийн хувь нэмрээ оруулах зорилгоор иргэдэд хууль зүйн тусlamж үйлчилгээг сайн дураараа өгөх, хохирогчдыг хууль шүүхийн байгууллагад хэрэг мэдүүлэхэд нь хөтөч болон ажиллаж эхлээд байна.

Улмаар хүний эрхийг хамгаалагчид өөрсдөдөө илтэд эрсдэлтэй үйлчилгээг өөрчилж хуулийн дагуу хийх ёстой төрийн албаны ажлыг сайжруулах нөлөөллийн ажил хийснээр “Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт цагдаагийн байгууллага дуудлагаар ажиллах журам”-ыг боловсруулан батлуулж УБ хотын Чингэлтэй дүүргийн Цагдаагийн албанд туршсан нь үр дүнгээ өгч байна.



GRANTEES SUCCESSES

DECISION MAKING AND PARTICIPATION

"Trivial Development" women's NGOs network of Zavkhan province have produced the policy "Participation of the Government, Civil Society and the Public in Tackling the Problems Women Face". This policy has been introduced to, and approved by local parliament during one of their sessions.

Now women of the Zavkhan province have their own development policy.

Also, this network has been working on monitoring the expenses and transparency of a budget of the state hospital in the province. These resulted in monthly reporting of the budget expenses and the situation on medicine of the Hospital to the general public.

Other provinces in the western region have expressed their interest in our project and are learning from the Zavkhan province experience.




GENDER BASED VIOLENCE

MONES has done numerous advocacy and awareness raising projects on fighting gender based violence.

One of the projects was the Global Campaign "16 days of Activism against Gender based Violence" organized by the National Centre against Violence (NCAV) since 1998. In the scope of the campaign NCAV organizes press conferences, movie screening in rural areas, "Date Rape" debates among students and high school pupils, and wide scale media campaigns.

A working group consisting of the members of civil society and local government organisations has been established in Uvs province and Buhmurun soum. In Ulaangom soum study has been conducted covering women, most vulnerable to violence, of 2 baghs. An awareness raising campaign on enforcement of law against domestic violence has been organized, also the future trends and work plan have been put up.

MONES continually supports work and operations of "Princess Centre", which works for the protection of victims of domestic violence, sexual abuse and teenage mothers' rights.



PROTECTION OF HUMAN RIGHTS DEFENDERS

MONES together with the National Centre against Violence (NCAV) has implemented "The Advocacy Action on Insuring Human Rights Defenders" project. In the scope of the project various advocacy activities have been conducted. Articles in newspapers were published and "Human Rights Protection in Mongolia" a debate among students of law colleges and universities was organized.



Many of these law students have started working with NGOs on a voluntary basis.

As the result of advocacy activities conducted by the NGOs police procedures were amended and approved on the actions in resolving domestic violence issues. The procedures were successfully carried out in one of the districts of Ulaanbaatar.



2009 ОНЫ ТЭТГЭЛЭГ АВАГЧДЫН АМЖИЛТААС

ДАВХАР БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮД

Эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, өрх тэргүүлсэн, олон хүүхэдтэй ажилгүй эмэгтэйчүүдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэн чадавхжуулах замаар тэдний гэр бүлийн амьжиригааг дэмжин орлого нэмэгдүүлэхэд туслахын тулд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Багануур дуурэг, УБ хотын Нар хур шим холбоо ТББ, Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг зэрэг эмэгтэйчүүдийн олон бүлгүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр, жишээ нь Дорнод аймагт 10 охин, 5 эмэгтэй гар урлалын 10 төрлийн бүтээгдэхүүн хийж суран 50-70 мянган төгрөгийн орлого олжээ. Хэнтий аймаг “Загвар гудамж” төсөл хэрэгжүүлэн иргэд өөрсдийн тулгамдсан асуудлаа өөрсдөө хамтран шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байна. Иргэдэд үйлчилгээ үзүүлэх зорилгоор 3 эмэгтэй тогтмол ажлын байртай болсон.

Багануур дуурэгт эмэгтэйчүүдийн 6 бүлэг байгуулагдан жижиг гар урлалын бүтээгдэхүүн хийх, цэцэг тарих зэрэг 250 мянган төгрөгийн борлуулалт хийж 44 эмэгтэй, тэдний ар гэрийн 120 гаруй хүний амьжиригаанд нөлөөлсөн ажил боллоо.

Сүхбаатар аймгийн эмэгтэйчүүд гэрийн бүрээс үйлдвэрлэх оёдлын жижиг цехтэй болж 3 эмэгтэй тогтмол ажлын байр, 690 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй болоод байна.

“Нар хур шим холбоо” УБ хотын захын хороолол болох Өлзийтөд уйл ажиллагаа явуулдаг билээ. Төсөлд хамрагдсан 21 эмэгтэй 3 бүлэг болон ажиллаж зүймэл даавуун урлал хийх, гутал оёх, ногоо тарих зэрэг ур чадвар эзэмшсэний үр дүнд эмэгтэйчүүдийн сарын дундаж орлого 10-50 мянган төгрөгөөр нэмэгдүүлж чадлаа.

Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн нэг чиглэл нь архины хамааралтай эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэхийн төлөө ажилладаг. Тэд МОНЭС-ийн санхүүжилтээр 2009 онд 10 эмэгтэйтэй ажиллан, орлого нэмэгдүүлэх хөтөлбөрт хамруулсны үр дүнд тухайн эмэгтэйчүүд ажлын хувцас хийж суран түүнийгээ борлуулж нэг хүн дунджаар 50-117 мянган төгрөгийн ашигтай ажилласан.



Эмзэг бүлгийн орлогогүй эмэгтэйчүүдийг чадваржуулснаар тэд өөртөө итгэлтэй болж багаар хамтран ажиллаж сурч байна. Мөн хөдөлмөрт дуртай болон цаашид олон нэр төрлийн бүтээгдэхүүн хийхийг эрмэлздэг болсноос гадна бусдад нөлөөлэх олон ажлыг хийхийг хүсч байна.

WOMEN WITH MULTIPLE DISADVANTAGES

MONES has been supporting many NGOs and initiatives that work on combating poverty among women, training them in handicrafts and other activities that would lead to income generation. Recent income generation projects for women with multiple disadvantages have been implemented in Dornod, Khentii, Sukhbaatar provinces and Baganuur district of Ulaanbaatar city.

In Dornod province the group members could increase their income by MNT 50-70 thousand. Ten girls and five women have been involved in handicrafts production, creating over ten types of handicrafts and they have established their own “Flourishing Women” club.

In Khentii province NGOs have implemented “Exemplary Street” projects, where villagers solve their problems through their active participation. 3 unemployed women have secured stable income by opening up a carpet cleaning service with the help of their community.

In Baganuur district 6 groups totaling 44 women have learned handcrafting and gardening and with the sales of their products have generated MNT 250 thousand, impacting the lives of over 120 people behind these women.

